

2023 оны 02 сарын 06 -ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, “Сэндли ББСБ” ХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.13, 8.6.14 дэх заалт, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 14 цагт Монгол Улс, Blue sky, 2 давхар, Emerald танхимд болон цахим хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хурал зарлах тухай мэдэгдлийг 2023 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг өөрийн болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 02 дугаар сарын 26-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.
6. Хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Наранбат-г томилсугай.
7. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:
 - 7.1. Хурал зохион байгуулах комиссын дарга:
 - 7.1.1. Б.Одгэрэл
 - 7.2. Хурал зохион байгуулах комиссын гишүүд:
 - 7.2.1. Х.Ичинхорлоо
 - 7.2.2. Т.Энхбаяр
8. Хурлаар танилцуулах болон хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн санал хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 16:40 цаг байхаар тогтоосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Б.Одгэрэл)-д даалгасугай.
11. Хурлын тооллогын комиссыг дараахи бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
 - 11.1 Хурлын тооллогын комиссын дарга:
 - 11.1.1 Д.Баярбат
 - 11.2 Хурлын тооллогын комиссын гишүүд:

11.2.1 А.Итгэлт

11.2.2 Н.Энхчимэг

12. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал хураалтыг цахим хэлбэрээр явуулах, үүнд санал хураалтанд оролцогчийг системд бүртгэх, түүний саналыг авах, авсан саналын дүнг өөрчлөх боломжгүйгээр гүйцэтгэх, хуралд оролцогч бүрийн өгсөн саналыг хэвлэж, үнэн зөв болохыг баталгаажуулж, компанид хүлээлгэж өгөх үүрэг хүлээх зохих туршлага бүхий мэдээллийн технологийн компанитай ажил гүйцэтгэх гэрээ байгуулж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 он 02 дугаар сарын 06-ны өдрийн
04 тоот тогтоолын Нэгдүгээр хавсралт



**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР
ТАНИЛЦУУЛАХ БОЛОН ХЭЛЭЛЦҮҮЛЖ, ШИЙДВЭРЛҮҮЛЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг танилцуулах;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэж, шийдвэрлүүлнэ. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах;

-----oOo-----

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн
0.7 тоот тогтоолын Гуравдугаар хавсралт



**“СЭНДЛИ ББСБ” ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ЗАР**

Хурал болох газар: Blue sky Tower, 2 давхар, Emerald танхимд болон цахимаар

Хурал болох өдөр, цаг: 2023 оны 04 сарын 07-ны өдрийн 14 цагт

Компанийн оноосон нэр: “Сэндли ББСБ” ХК

Хурлаар хэлэлцэх асуудал:

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг танилцуулна. Үүнд:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах;
2. Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэрийг танилцуулах;

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны төсөв батлах;

Бүртгэлийн өдөр: 2023 оны 03 сарын 02-ны өдөр

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн төсөл;
2. Компанийн санхүүгийн жилийн тайлан;
3. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
4. Саналын хуудас;
5. Компанийн тухай хуулийн 65.6-д заасан шаардлагатай бусад бичиг баримт.

Хувьцаа эзэмшигчид өөрийн харилцагч үнэт цаасны компани, хурал зохион байгуулах комисстой холбогдож, эсхүл компанийн цахим хуудсаар дамжуулан хурлаар хэлэлцэх асуудал болон гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцаж болно.

Хурал зохион байгуулах комиссын гишүүдтэй Даваагаас Баасан гаргуудад 09-17 цагийн хооронд дор дурдсан хаяг, утсаар холбогдох боломжтой.

Хаяг: Улаанбаатар хот, “Сэндли ББСБ” ХК-ийн оффис

Харилцах утас: 70177700

Цахим шуудан: info@sendly.mn

Хурал зохион байгуулах комисс

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20²³ оны 02 сарын 06 -ны өдөр

№ 05

Улаанбаатар хот

Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид Компани гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.16 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг “Хангалттай” гэж дүгнэсүгэй.
2. Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон, СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд “Шонхор үнэлгээ аудит” ХХК-ийн гаргасан аудиторын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
3. Компанийн үйл ажиллагаа болон аудитлагдсан санхүүгийн тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж, зохих шийдвэрийг гаргуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Б.Наранбат)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 06-ны өдөр

№ 06

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.12 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.8 дахь заалт, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.8.6 дахь заалт, Ногдол ашгийн бодлогын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Сэндли ББСБ” ХК-ийн 2022 оны татварын дараах цэвэр ашгаас Компанийн хувьцаа эзэмшигчдэд олгох ногдол ашгийн нэгж хувьцаанд ногдох хэмжээг 2.75 (хоёр төгрөг далан таван мөнгө)-өөр тогтоож, 2022 оны цэвэр ашгаас 20.064 хувийг буюу 614,817,500.0 (Зургаан зуун арван дөрвөн сая найман зуун арван долоон мянга таван зуу) төгрөгийг Компанийн хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах эрхтэй Компанийн энгийн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрөөр тогтоосугай.

3. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасан ногдол ашгаас хувь хүний болон хуулийн этгээдийн хувьд аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг суутган тооцож, “Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК-аар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн дотор олгосугай.

4. Ногдол ашиг хуваарилж, олгох тухай шийдвэрийг хувьцаа эзэмшигчдэд хүргэх, ногдол ашгийг холбогдох хууль тогтоомж, энэхүү тогтоолд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд олгохыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.НАРАНБАТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 06-ны өдөр

№ 07

Улаанбаатар хот

*Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтооёж,
гэрээний нөхцөл батлах тухай*

Монгол Улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, 76 дугаар зүйлийн 76.1.9 дэх заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.6 дахь заалт, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг Хавсралтад заасан гэрээний дагуу олгосугай.
2. Батлагдсан гэрээний төслийн дагуу Гүйцэтгэх захиралтай гэрээ байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Б.Наранбат)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 06-ны өдөр

№ 08

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны санхүүгийн болон бизнесийн төлөвлөгөөг батлах тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.1 дэх заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Компанийн 2023 оны санхүүгийн төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар, 2023-2025 оны бизнесийн төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.НАРАНБАТ



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 06-ны өдөр

№ 09

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.20 дахь заалт, Нэгдмэл сонирхолтой этгээдтэй хийх хэлцэл, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь нэгдмэл сонирхолтой нэр бүхий компаниудтай нэг улиралд нийт 5'000'000'000.0 (Таван тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүнтэй хэлцэл буюу сонирхолын зөрчилтэй хэлцлийг хавсралтад заасан нөхцөлөөр байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-д дурдсан эрх хэмжээний хүрээнд сонирхолын зөрчилтэй хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д олгосугай.
3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан эсэх талаарх мэдээллийг Төлөөлөн удирдах зөвлөлд улирал бүр тайлагнаж байхыг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын 3-д заасан тайланг үндэслэн Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрлийн хугацааг сунгах эсэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар шийдвэрлэхийг дурдсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА





**Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх
нөхцөл**

№	Компанийн нэр	Хэлцлийн нөхцөл
1	Монголын финтек групп ХК	Эх үүсвэр авах
2	Мони маркет фонд ХХК	Эх үүсвэр өгөх, авах

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 06 -ны өдөр

№ 10

Улаанбаатар хот

Салбарын хаяг өөрчлөх тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “Сэндли ББСБ” ХК (Цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.29 дэх заалт, Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн ээлжит хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Дорнод салбарын хаягийг Дорнод аймаг, Хэрлэн сум, 9-р баг, Сити центр, 2 давхар болгон өөрчилсүгэй.
2. Компанийн Нарантуул салбарын хаягийг Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 19/1-403 тоот болгон өөрчилсүгэй.
3. Компанийн Дорноговь салбарын хаягийг Дорноговь аймаг, Сайншанд сум, 3-р баг, Цахим-Ундраа төв, 2 давхар болгон өөрчилсүгэй.
4. Салбарын хаяг өөрчлөгдсөнтэй холбоотойгоор компанийг төлөөлж Түрээсийн гэрээ байгуулах эрхийг Салбарын захирлуудад олгосугай.
5. Салбарын хаяг өөрчлөхтэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрөл авах ажлыг хийж гүйцэтгэхийг Гүйцэтгэх захирал (Б.Одгэрэл)-д, салбарын хаягийн өөрчлөлт болон түрээсийн гэрээг Улсын бүртгэлд бүртгүүлэхийг Салбарын захирлуудад тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

